

БАТЛАВ  
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА И.БАТТӨГС

2024 оны ... дугаар сарын ...

БУЛГИЙН ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛАХ ТОХИЖИЛТ, ЗАСВАРЫН (УЛААНБААТАР,  
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ) АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

1	Үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль</li><li>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль</li><li>- Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 107 дугаар тогтоол</li></ul>
2	Байршил	<ul style="list-style-type: none"><li>- Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо хуандай ам, Мухартын булаг. (47°57'44.6"N 107°16'09.2"E)</li><li>- Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо арцат төвийн булаг. (47°57'28.2"N 107°14'54.5"E)</li><li>- Баянзүрх дүүргийн 34 дүгээр хороо Улиастайн амны Сайханы булаг. (47°57'47.41"N, 107° 1'21.13"E)</li></ul>
3	Зориулалт, хүчин чадал	<ul style="list-style-type: none"><li>- Булаг тус бүрд орчны нөхцөл байдалтай уялдуулан булгийн эх, тэжээгдлийн бүсийг байгальд ээлтэй материалаар хашаалж, нутгийн оршин суугчдын ус авах, мал ундаалах нөхцөлийг бүрдүүлж өгөх;</li><li>- Булгийн эхийг хамгаалсан хашаа нь хүн, мал, амьтан орохооргүй байхаар төлөвлөх бөгөөд 20 метр (25м.кв талбайг хамрах) байна;</li><li>- Тэжээгдлийн бүсийг хамгаалсан хашаа нь 120 метр (900м.кв талбайг хамрах) байх бөгөөд хүн орж ус авах зориулалтай явган хаалга хийж мал амьтан орохоос сэргийлж оньсон цоожтой байна. (Явган хаалга нь мал орохоос сэргийлэх зохиомжтой байж болно.);</li><li>- Хашааны шонгуудыг газарт 80см-ээс доошгүй гүнд суулгана;</li><li>- Хашааны тулгуур багана хооронд 2 метрээс багагүй, хашааны өндөр нь 1,2-1,8 метр байна;</li><li>- Хүн ус авах хэсгээс явган хаалга хүртэл байгалийн чулуугаар хийсэн явган замтай байна;</li><li>- Мэдээллийн самбар байгуулна;</li><li>- Хашаа нь бат бөх байхаас гадна хөрсний овойлт, суултад тэсвэрлэх чадвартай байх;</li></ul>
4	Зураг төслийн бүрдэл	<ul style="list-style-type: none"><li>- Тохижилтын ажлын норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлын 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх;</li><li>- Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн UTM буюу солбилцолын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх;</li></ul>
5	Ажил гүйцэтгэх үе шат, хугацаа	<ul style="list-style-type: none"><li>- Ажлын зураг төсвийг зохиохдоо газар дээр нь үзэж, хэмжилтийн зураг гаргуулан, ажлын зураг боловсруулж, төсөвт магадлал хийлгэх;</li><li>- Захиалагч гүйцэтгэгч талууд хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно;</li></ul>
6	Төслийн байгууллага	<ul style="list-style-type: none"><li>- Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага;</li></ul>


7	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Тендерт үнийн санал ирүүлэхдээ газар дээр нь судалж, ажлын тоо хэмжээг тооцож ирүүлэх;</li> <li>- Ажлын төсвийг боловсруулж магадлалаар баталгаажуулсны дараа угсралтын ажлыг эхэлнэ;</li> <li>- Зураг төслийг хот байгуулалтын норм дүрмийн дагуу төлөвлөх бөгөөд Байгаль орчны тухай хууль тогтоомж болон холбогдох стандартуудыг мөрдлөг болгоно;</li> </ul>
8	Төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна. <ul style="list-style-type: none"> <li>а) Нийслэлийн байгаль орчны газар ;</li> <li>б) Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар ;</li> <li>с) Холбогдох бусад байгууллага;</li> </ul> </li> </ul>
9	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Уг ажлыг гүйцэтгэхэд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах норм дүрмүүдийг баримтлан ажиллах шаардлагатай. Үүнд:</li> <li>- MNS 5874-2008;</li> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/;</li> <li>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/;</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм;</li> <li>- Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12;</li> <li>- Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх UCS стандарт, шаардлагуудыг тус тус мөрдөх</li> </ul> <p><u>Төсөл, хөтөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;</li> <li>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;</li> <li>- Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;</li> </ul>
10	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн төсвийн программаар тооцох</li> </ul>

ХЯНАСАН:  
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Н.БИЛЭГСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:  
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



О.ТҮВШИНТӨГС